

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Монгол орны хүнсний ногооны үйлдвэрлэлийн эрсдэлийн удирдлага – боломж, бэрхшээлүүд



Герман – Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл

Др. Лена Кунн, Др. Ихтёр Бобожонов

2020 оны 10 сар



Тайлбар: Энэхүү судалгааны тайланг Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийн хүрээнд боловсруулав. Уг судалгаанд багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцах бөгөөд “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Зохиогчид:

Др. Лена Кунн, Др. Ихтёр Бобожонов

ХБНГУ-ын Лайбницийн Шилжилтийн эдийн засагтай орнуудын хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээлэн (IAMO)

Хэвлэсэн:

Герман – Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төсөл

Copyright ©2020, Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төсөл

Төсөл хэрэгжүүлэгч:



Агуулга

1. Оршил.....	3
2. Мэдээлэл цуглуулалт.....	6
3. Судалгааны байдал.....	7
3.1. Тариалан эрхэлдэг аж ахуйн нөхцөл байдал	7
3.2. Үйлдвэрлэлийн байдал, тариалангийн технологи ба бүтээмж.....	7
4. Хүнсний ногооны тариалангийн уур амьсгалын ба зах зээлийн эрсдэл	11
4.1. Тариаланчдад тулгарч байгаа эрсдэлүүд	11
4.2. Үйлдвэрлэлийн ба зах зээлийн эрсдэлийг даван туулах.....	13
4.3. Эрсдэл тэсвэрлэх чадварыг сайжруулах аргууд.....	14
4.3.1. Эрсдэлийн удирдлагын уламжлалт аргуудыг хэрэглэх нь	14
4.3.2. Нэвтрүүлэх үйлчилгээний гүйцэтгэх үүрэг	15
4.3.3. Дижитал технологийн гүйцэтгэх үүрэг	16
4.3.4. Нийлүүлэлтийн сүлжээний гүйцэтгэх үүрэг	17
5. Шүүн хэлэлцүүлэг ба зөвлөмж.....	18
Ашигласан хэвлэл	21
Хавсралт: Түүврийн байршил.....	22

Монголын орны хүнсний ногооны үйлдвэрлэлийн эрсдэлийн удирдлага – боломж, бэрхшээлүүд


Доктор Лена Кунн, Доктор Ихтёр Бобожонов

ХБНГУ-ын Лайбницийн Шилжилтийн эдийн засагтай орнуудын хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээлэн

1. Оршил

Монгол улсын хөдөө аж ахуйн салбар, ялангуяа мал аж ахуйн салбар нь ажиллах хүчний хангамж болон хүнсний аюулгүй байдалд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүнс, тэжээлийн чанар, аюулгүй байдлыг сайжруулахтай холбоотойгоор газар тариалангийн салбарын үүрэг сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэж байна. Тухайлбал, гурилан бүтээгдэхүүн, сүү, мах нь хүний өдөр тутам авах ёстой илчлэгийн 86%-ийг эзэлж байна (НҮБХХААБ, НҮБ-ийн Хүүхдийн Сан, НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, 2007). Монголчуудын уламжлалт хоолны дэглэмд хүнсний ногооны хэрэглээ маш хязгаарлагдмал байдаг боловч сүүлийн жилүүдэд ялангуяа хотын оршин суугчдын дунд хүнсний ногооны эрэлт нэмэгдэж байна. Монгол улсад 1990-ээд оны эхээр төмс, хүнсний ногооны тариалалт огцом бүүрснаас шалтгаалан үүссэн хомсдлыг нөхөхийн тулд Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д Монгол улс гишүүнээр нэгдэн орж худалдааны либералчлал хийснээр гадаад улс, орнуудаас тэр дундаа Хятад улсаас импортлох төмс, хүнсний ногооны хэмжээ 1990-ээд оны сүүлээр эрчимтэй нэмэгджээ (ХХААБСТАТ, 2020).


Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газраас хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үнийг тогтворжуулах нь чухал зорилтууд болоод байгаа (АХБ, 2020) тул дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлжээ. Үүнд: Үндэсний хөгжлийн хөтөлбөрийн (2008-2012) хүрээнд хэрэгжүүлсэн “Атрын 3 дахь аян” Үндэсний хөтөлбөр, Монгол улсын Хүнсний аюулгүй байдлын Үндэсний хөтөлбөр (2009-2016), “Хүнсний ногоо” Үндэсний хөтөлбөр (2018-2020), УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол зэрэг болно (АХБ, 2020; Пешк, 2016). Монгол улсын хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хувь нэмэгдэж байгааг Азийн Хөгжлийн Банк статистикийн мэдээнд тулгуурлан мэдээлсэн (АХБ, 2020) бөгөөд энэ нь дээрх бодлого, хөтөлбөрүүд хэрэгжсэний үр дүн байх магадлалтай. Хэдийгээр, хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх олон хөтөлбөр, эерэг хандлагууд байгаа боловч 2010 оноос хойш үйлдвэрлэлийн хэмжээ болон хэрэглээ дорвитой өсөөгүй байна (Зураг 1).




Зураг 1: Хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээ ба хэрэглээ

Эх сурвалж: (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2020)

Хүнсний ногооны үйлдвэрлэлийн өсөлтийн зэрэг удаашралтай байгаагийн үндсэн шалтгаан нь ургацын хэмжээ хэвийн эсвэл маш аажмаар нэмэгдэж байгаатай холбоотой юм. Монгол, Хятад, Казакстан болон Орос зэрэг хөрш зэргэлдээ орнуудын хүнсний ногооны ургацын өсөлтийг харьцуулан судлав (Зураг 2). Эндээс үзэхэд, нэгдүгээрт, Монгол улсын хураасан ургацын хэмжээ бусад орнуудын үзүүлэлтээс доогуур байна. Хоёрдугаарт, 1992 оноос хойш Монгол улсын хүнсний ногооны ургацын хэмжээнд бараг өсөлт ажиглагдаагүй бол энэ хугацаанд бусад орнуудын ургац 200 гаруй хувиар нэмэгджээ. Ургацын хэмжээ бага байгаагийн гол шалтгаан нь үйлдвэрлэлийн орцод хөрөнгө оруулалт бага хийсэнтэй холбоотой юм.





Зураг 2: Монгол улсын хүнсний ногооны ургацын га-ийн дундаж ургацын хэмжээг хөрш орнуудынхтай харьцуулсан байдал Эх сурвалж: (ХХААБСТАТ, 2020)


Аливаа эргэлзээтэй байдал нь хөрөнгө оруулалтыг гацаахад хүргэдгийн адилаар тариаланчдын үйлдвэрлэлийн эрсдэлд өртөмтгий байдал нь ургац өсөхгүй, хэвийн хэмжээнд байгаагийн үндсэн шалтгаан байж болно. Тухайлбал, (1) Монголын хүнсний ногооны салбар нь байгаль, цаг уураас хараат, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байна. Бусад орны нэгэн адил, Монгол улс нь олон төрлийн байгалийн эрсдэлийн дор оршдог тул энэ байдал нь газар тариалан эрхлэхэд шүүд нөлөөлдөг. Азийн Гамшгийн Аюулыг Бууруулах Төв (АГАБТ)-өөс Монгол улсад тохиолдох гол байгалийн гамшгуудын жагсаалтад ган гачиг, газар хөдлөлт, тахал, өлсгөлөн, үер, ойн түймэр, салхины ба цасны гамшиг (зуд) зэргийг оруулжээ (АГАБТ, 2020). Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны мэдээнээс харахад 2009 – 2019 оны хооронд тохиолдсон 4200 удаагийн байгалийн гамшгийн учруулсан нийт хохирол нь жилд дунджаар 95 тэрбум төгрөгт (28.4 сая евро) хүрчээ. Дээр дурдсан арван жилийн хугацаанд гарсан 2008 орчим ойн болон талын түймэрт ойролцоогоор 28 сая га талбай шатсан байна (МСМС, 2020). Монгол улсад тохиолдож буй уур амьсгалын өөрчлөлт нь байгаль, цаг уурын энэхүү хатуу ширүүн нөхцлийг улам дордуулах болно. Агаарын температур нэмэгдэж байгаа хандлага нь монголын хүнсний ногооны үйлдвэрлэлд тааламжтай нөлөө үзүүлэх мэт боловч дэлхийн дулааралтай холбоотой тохиолдож байгаа цаг агаарын эрс тэс нөхцлийн давтамж нэмэгдэх нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг эргэлзээтэй болгон ургац алдахад хүргэж болзошгүй юм. (2) Эдгээр уур амьсгалын эрсдэлүүд нь сул хөгжсөн өртгийн сүлжээнээс хамаарч бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эрсдэлийг нэмэгдүүлэх, улмаар байдлыг илүү хүндрүүлэх болно. Тухайлбал, дотоодын таримал ургамлын үр үржүүлгийн салбар сул хөгжсөн нь тариалангийн үйлдвэрлэлийн хөгжилд бэрхшээл учруулж байна. Монгол улс хүнсний ногооны үрийг гол төлөв Хятад, Орос улсаас импортлодог юм. Гэхдээ Хятад улсаас импортолсон үр нь Монгол улсын байгаль, цаг уурт дасан зохицоогүй байдгийг дурдах нь зүйтэй (Пешк, 2016).

Газар тариалангийн үйлдвэрлэлийн болон зах зээлийн эрсдэлийн талаар тариаланчдын үзэл бодол, тэдний эргэлзээтэй байдалд үзүүлж байгаа хандлага нь одоогийн байдлаар бага судлагдсан байна. Монголын хүнсний ногооны салбарын боломж, бэрхшээлийн талаарх дүн шинжилгээг өмнө нь дан статистикийн нэгдсэн мэдээлэл, мэргэжилтний өгсөн дүн мэдээ болон асуулга бөглүүлэх судалгаа зэрэгт тулгуурлан гүйцэтгэдэг байв. Одоог хүртэл аж ахуйн нэгжийн түвшний мэдээлэл дээр тулгуурлан газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тулгарч буй хүндрэлүүдийг тодорхойлох иж бүрэн, бодит байдлын задлан шинжилгээ хийгдээгүй байна. Эрсдэл тулгарч буй үндсэн шалтгаан болон түүнийг даван туулах, дасан зохицох арга хэмжээг цогцоор нь задлан шинжлэх нь Монгол

улсын хүнсний ногооны өртгийн сүлжээний цаашдын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах болно. Энэ тайлан нь тариалан эрхэлдэг аж ахуйд тохиолдож байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэл, зах зээлийн эрсдэлтэй холбоотой асуудлуудыг нарийвчлан тогтоох, газар тариалангийн үйлдвэрлэлд учирч буй саад бэрхшээлүүдийг тодорхойлох зорилготой асуулгын дагуу цуглуулсан мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэсэн анхан шатны судалгаа юм.

2. Мэдээлэл цуглуулалт

Монголын хүнсний ногоо хэрэглэгчдийн эрсдэл ба эрсдэлийн удирдлагын нарийн дүн шинжилгээ хийх зорилгоор бид Монгол улсын хүнсний ногооны ихэнх хэсгийг тариалдаг голлох бүс нутгуудыг хамруулсан аж ахуйн түвшний асуумж судалгааг гүйцэтгэв. Нийт 308 тариаланчдаас мэдээлэл цуглуулах ажлыг 2020 оны 7, 8-р сард багтаан хийсэн юм. Судалгаанд хамрагдах тариаланчдын төлөөллийн түүврийн хэмжээг тогтоохдоо санамсаргүй магадлал бүхий түүврийн аргыг ашиглав. Түүвэр судалгаанд хамрагдсан аймгуудын ногоочдын тоог тогтоохдоо хүнсний ногооны үндэсний үйлдвэрлэлд тухайн аймгийн эзлэх хувьд нь тулгуурласан болно. Үүнээс гадна өрхийн тариалан, хоршоо, аж ахуйн нэгж гэсэн газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг хамгийн түгээмэл төрлүүдийг сонгон судлахад онцгой анхаарал хандуулсан юм. Судалгаанд хамрагдах ахуйн нэгжийн тоог хүнсний ногооны нийт үйлдвэрлэлд тэдний эзлэх хувьд нь үндэслэн түүврийн аргаар тогтоов. Харин санамсаргүй болон тохиолдлын түүвэрлэх аргыг хослуулан сумын ХАА-н газраас өгсөн нэрсээс сумын түвшний ногоочдыг сонгон авсан болно. Аймгуудын газар тариалан эрхэлдэг аж ахуйдын тархац болон төрлийг Зураг 3-т үзүүлэв. Сумдын газар тариалан эрхэлдэг аж ахуйдын тархцыг гаргахдаа түүврийн магадлалын аргыг ашиглан газар тариалангийн үйлдвэрлэлд тухайн сумын эзлэх хувиас нь шалтгаалан тодорхойлов. Судалгааны ярилцлагад хамрагдсан тариаланчдын газарзүйн байршлыг Хавсралтад үзүүлэв.



Зураг 3: Түүврийг а) аймаг болон б) тариалангийн аж ахуйгаар үзүүлсэн нь

3. Судалгааны байдал

3.1. Тариалан эрхэлдэг аж ахуйн нөхцөл байдал

Түүвэр судалгаанд хамрагдсан тариаланчдын боловсролын түвшин харьцангуй өндөр байв. Тариалангийн аж ахуй эздийн 37% нь их сургуулийн боловсролтой, 27.6% нь техникийн коллежд суралцсан байсан бол зургааны нэг нь дунд сургуулийн (13%), тавны нэг нь ахлах сургуулийн боловсролтой (21.8%) байлаа. Харин боловсролын түвшнээс үл хамааран нийт тариалангийн аж ахуйн менежерүүдийн 52.8% нь ХАА-н тусгай мэргэжлийн боловсрол эзэмшсэн байв. Тариалангийн аж ахуйн эздийн дундаж нас 49 байсан бөгөөд энэ үзүүлэлт нь олон улсын стандартаар харьцангуй залууд тооцогдоно. Судалгаанд хамрагдсан тариаланчид нь дунджаар 17 жил газар тариалан эрхэлсэн туршлагатай байсан ба тэдний талаас илүү (56.5%) нь дан ганц хүнсний ногоо тариалдаг биш, давхар хөдөлмөр эрхэлж, орлого олдог байв.

Бидний таамаглаж байснаар, тариалан эрхэлдэг аж ахуйн төрлүүдийн газар тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээ нь хоорондоо маш их ялгаатай байв. Өрхийн тариаланчид ба үйлдвэрлэл эрхлэгч хоршоодын тариалангийн нийт талбай нь харьцангуй бага байв. Түүвэр судалгаанд хамрагдсан өрхийн үйлдвэрлэгчдийн тариалангийн талбайн дундаж хэмжээ нь 3.6 га, хоршоодынх 4.3 га, харин аж ахуйн нэгжийнх 69.1 га байв. Тариаланчдын үсалгаатай тариалангийн хэмжээ нь дунджаар нийт талбайн 79.4%-ийг эзэлж байсан бол аж ахуй нэгжийн хувьд нийт талбайнхаа тал хувийг л үсалгаажуулсан байна. Бүх тариалангийн аж ахуйд төрлөөсөө хамааралгүйгээр нэг жилд га тутамд дунджаар 2.4 байнгын ажилчин, 29.9 түр ажилчин нэмэлтээр авч ажиллуулдаг бөгөөд энэ нь хүнсний ногооны үйлдвэрлэлийн улирлын шинж чанартай байдгаар тайлбарлагдана. Тариалангийн төрлүүд нь түр ажилчдын тоогоороо хоорондоо бараг ялгаагүй байсан бол өрхийн тариаланчид ба үйлдвэрлэл эрхлэгч хоршоодын байнгын ажилчдын тоо нь аж ахуйн нэгжийнхээс илүү байв. Тариалан эрхэлдэг том аж ахуйн нэгжүүд нь тодорхой бүлэг ногоог дангаар нь тариалдаг бол (дунджаар 1.8 төрлийн хүнсний ногоог) жижиг эсвэл дунд хэмжээний тариалангийн аж ахуйн нэгжүүдийн хувьд илүү олон нэр төрлийн ногоо тариалдаг байна (дунджаар 2.4 - 2.7 төрлийн).

Хүснэгт 1: Хүнсний ногоо тариалагчдын тариалан эрхэлж байгаа байдал (дундаж үзүүлэлтээр, аймгаар)

	Нийт талбай (га)	Усалгаатай тариалан (%-иар)	Байнгын ажилчид (хүн/га)	Түр ажилчид (хүн/га)	Тарим-лын төрөл	Хүнсний ногооны төрөл
Өрхийн тариаланчид	3.60	82.91%	3.00	29.11	3.41	2.42
Аж ахуйн нэгжүүд	69.08	53.15%	0.52	28.93	3.24	1.84
Үйлдвэрлэл эрхлэгч хоршоод	4.25	91.29%	2.06	33.83	3.69	2.73
Нийт	14.55	79.37%	2.44	29.86	3.43	2.37

3.2. Үйлдвэрлэлийн байдал, тариалангийн технологи ба бүтээмж

Хүснэгт 2-т бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой үндсэн тоон мэдээллийг үзүүлэв. Энэ мэдээллээс харахад, төмс, шар лууван нь судалгаанд хамрагдсан хүнсний ногоо тариаланчдын хувьд үндсэн таримал байна. Учир нь эдгээр таримлыг тариалж байгаа аж ахуйн тоо (244 аж ахуй төмсийг, 201 аж ахуй шар лууванг) болон ургацын хэмжээ нь (25.4 мянган тонн төмс, 5.5 мянган тонн шар

лууван) тухайн ногоочдын голлон тариалдаг үндсэн таримлууд болохыг баталж байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан олон аж ахуй нь сонгино, байцаа, шар манжин, урт болон богино өргөст хэмхийг үндсэн тарималд тооцон тариалдаг байна. Тариалсан таримлын бүрэлдэхүүний хувьд аймгуудын хооронд бага ялгаатай, харин Орхон, Сэлэнгэ, Төв, Улаанбаатарын хувьд ялгаа ихтэй байсан боловч эдгээрийн хоёр дахь чухал хүнсний ногоо нь шар лууван байв. Үүнээс гадна хүнсний ногооны төрлүүдийг тариалах ээлжлэн тариалалт нь бүх аймгуудад ижил төстэй байв.

Хүснэгт 2: Хүнсний ногооны тариалалт (түүвэр судалгааны хувьд)

	Шар лууван	Шар манжин	Сонгино	Байцаа	Урт ба богино өргөст хэмх	Төмс
Тариалан эрхэлдэг нийт аж ахуй	201	114	135	124	95	244
Нийт ургац (тонноор)	5504.8	1259.1	623.2	7551.7	335.0	25412.6

Хүснэгт 3-т тариалангийн аж ахуйн төрлүүдийн тариалсан үндсэн хүнсний ногооны ургацын хэмжээг үзүүлэв. Тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь таамаглаж байснаар хамгийн их ургацыг хурааж аваагүй байна. Харин үйлдвэрлэл эрхлэгч хоршоодын хувьд хүнсний ногоо бүрээс хамгийн их ургацыг хураан авчээ. Тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн ургац нь өрхийн тариалангаас бага зэрэг илүү эсвэл зарим тохиолдолд бага байна. Тариалангийн аж ахуйдын хурааж авсан ургац нь ихэнх хүнсний ногооны хувьд У-хэлбэртэй байв. Талбайн хэмжээ нь 5 га-аас бага эсвэл 50 га-аас илүү тариаланчид нь нэг га-гаас хамгийн их ургац хураан авсан бол 5-50 га талбай бүхий дунд хэмжээний тариаланчид нь байцайнаас бусад ногооноос бага хэмжээний ургац хураан авчээ. Том тариалангийн аж ахуй эрхлэгчид нь үйлдвэрлэлээ нэмэгдүүлж зардлаа бага зэрэг бууруулах талаар анхаарч ажилласан бол жижиг тариалангийн аж ахуй эрхлэгчид нь ажиллах хүчний тоо, таримлын бүтцийн сонголтыг илүү уян хатнаар зохицуулж ажилласан нь харагдаж байна.

Хүснэгт 3: Голлох хүнсний ногооны ургац, тариалангийн аж ахуйн төрлөөр (тонн/га)

	Шар лууван	Шар манжин	Сонгино	Байцаа	Урт ба богино өргөст хэмх	Төмс
Тариалангийн төрөл						
Өрхийн тариаланчид	15.36	12.21	11.59	21.30	31.35	15.38
Аж ахуйн нэгж	16.38	8.82	8.99	25.15	32.46	15.91
Үйлдвэрлэл эрхэлдэг хоршоо	18.22	16.14	13.43	30.67	57.76	16.92
Талбайн хэмжээ						
<5га	16.37	14.34	12.58	23.14	34.23	15.99
5-10га	14.35	8.59	7.15	24.29	18.98	15.40
10-50га	13.79	8.74	10.70	27.87	19.07	14.67
>50га	21.20	12.94	14.08	21.47	25.00	17.16
Нийт	16.00	12.50	11.63	23.81	36.28	15.74

Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйдын 89% орчим нь хүнсний ногооны нэр төрлийн нэмэгдүүлснээр орлогоо нэмэгдүүлэх боломжтой гэж үзсэн нь олон нэр төрлийн хүнсний ногоо тариалахын ач холбогдлыг тэд ойлгож байгааг илэрхийлж байна. Тариаланчдаас одоо тариалж байгаа таримлын бүрэлдэхүүн, үйлдвэрлэлийн талаар асуухад 52.9% нь сэтгэл хангалуун байгаа гэсэн

бол 44.8% нь нэр төрлийг нь илүү ихээр нэмэгдүүлэх хүсэлтэй байгаа гэжээ. Тэднээс таримлын нэр төрлийг нэмэгдүүлэхэд саад болж байгаа голлох шалтгаануудыг нь асуухад нийт оролцогчдын 62.3% нь тохиромжтой тоног төхөөрөмж байхгүй, 59.4% нь хүнсний ногооны үнэ тогтворгүй, хэлбэлзэл ихтэй, 49.3% нь зээл авахтай холбоотой хүндрэл, 42% нь өрхийн ам бүл цөөн, хөдөлмөрлөх хүчний хангалтгүй байдал зэрэгтэй холбон хариулсан байна (Зураг 4). Түүнчлэн үйлдвэрлэлийн хэмжээ, зах зээл нэмэгдэхэд эрсдэлтэй байдаг талаар дөрвөн удаа, тариаланд тохиромжтой газар нутаг дутагдалтай байдаг талаар дөрвөн удаа, шаардлагатай хөрөнгө оруулалт хийх санхүүжилт хангалтгүй байдаг талаар хоёр удаа, ажиллах хүчний хомсдол гардаг талаар хоёр удаа тус тус дурджээ. Ялангуяа “үнийн тогтворгүй байдал” болон олон төрлийн таримал тариалах тохиолдолд гардаг нэмэгдэл эрсдэлийн талаар ил тодоор илэрхийлж байсан нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлд тулгардаг ерөнхий бэрхшээлүүдээс гадна цаашид зах зээлийн болон үйлдвэрлэлийн эрсдэлүүд тулгарч болзошгүй байгааг харуулж байна.




Зураг 4: Таримлын нэр төрлийг нэмэгдүүлэхэд тулгарах саад бэрхшээлүүд (n=138)

Үүнээс гадна бид үйлдвэрлэлийн орцыг худалдан авахтай холбоотой асуудлуудыг судалсан болно (Зураг 5). Судалгаанд хамрагдсан тариаланчдын 66% нь үйлдвэрлэлийн орцыг худалдан авахад хүндрэл учирдаг талаар илэрхийлсэн. Сонирхолтой нь тариалангийн аж ахуйн төрлүүдийн хооронд энэ талаар томоохон ялгаа байхгүй байв. Өрхийн тариаланчид болон тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд тулгардаг бэрхшээл нь ижил төстэй (64-65%) байсан бол харин хүнсний ногоо тариалагчдын хоршоод нь өрхийн тариаланг бодвол дэвшилтэт хэлбэрийн орцыг илүү ихээр шаарддаг боловч аж ахуйн нэгжийг бодвол эх үүсвэр хайх дэвшилтэт арга тэдэнд байдаггүй тул тэдний нийт худалдан авалтын 76% орчимд бэрхшээл тохиолддог байна. Судалгаанд хамрагдсан тариаланчдын мэдээлснээр, дэлгүүрт очих боломжгүй (32% нь), очих боломжтой ч шаардлагатай байгаа орц тухайн дэлгүүрт байхгүй (41% нь), байсан ч тухайн шаардлагатай орцын үнэ хэт өндөр (24% нь) зэрэг хүндрэлүүдийг онцлон дурджээ. Үйлдвэрлэлийнхээ орцыг нэмэгдүүлснээр ургацын хэмжээг өсгөх, улмаар газар тариалангийн үйлдвэрлэлийн ашгийг нэмэгдүүлдэг. Үүний үр дүнд ганд тэсвэртэй шинэ сортууд гаргах ажиллагааг ч дэмжих боломж бүрдэх юм. Үйлдвэрлэлд шаардлагатай орцуудын хангамжгүй буюу бэлэн бус байдал нь бидний судалгаанд хамрагдсан ихэнх тариаланчдын хувьд эрсдэлээ бууруулахын тулд хийх сонголт биш, эрсдэлийн удирдлагын хэрэгсэл биш гэдэг нь тодорхой байна.



Зураг 5: Үйлдвэрлэлийн орц худалдан авахад тулгардаг асуудлууд (бордоо, пестицид, үр г.м)

Хүнсний ногооны үйлдвэрлэлтэй холбоотой өөр нэг чухал хүчин зүйл нь хүлэмжийн технологийг нэвтрүүлэх юм. Энэ технологи нь байгалийн тодорхой гамшгийн хор нөлөөг багасган хүнсний ногооны тариалангийн эрсдэлд өртөмтгий байдлыг бууруулах боломж олгодог. Зураг 6-д үзүүлснээр судалгаанд хамрагдсан тариаланчдын дөнгөж 13% буюу 40 нь хүлэмжийн үйлдвэрлэлийг эрхлэн урт болон богино өргөст хэмхийг голдуу тариалж байна. Урт болон богино өргөст хэмх тариалдаг хүлэмжийн тариалан нь судалгаанд хамрагдсан ногоочдын нийт тариалангийн талбайн гуравны нэгийг (33%) эзэлж байв. Хүлэмжийг тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүд хамгийн их (56%), үйлдвэрлэл эрхэлдэг хоршоод нь дунд зэрэг (47%), харин өрхийн тариаланчид хамгийн бага хэмжээгээр хэрэглэдэг (26%) болох нь судалгаагаар харагдав. Энэ тоон үзүүлэлт нь хүлэмжийн үйлдвэрлэлийг нэвтрүүлэхэд шаардагддаг их хэмжээний хөрөнгө оруулалттай шууд холбоотой юм. Хөрөнгө ихтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой байдаг. Үүнээс гадна хүлэмжийн тариалан эрхлэхэд тохиолддог ажиллах хүчний дутагдал, борлуулалттай холбоотой бэрхшээл, эсвэл түршлага муутай байдал зэрэг бусад асуудлуудыг дурдаж болох юм. Дээрх мэдээлэл дээр үндэслэн тариалангийн аж ахуйн эрсдэлийн удирдлагатай үндсэн хөрөнгийн асуудал шууд холбоотой болохыг онцлон дурдмаар байна.



Зураг 6: Хүлэмжийн технологийн ашиглалтын байдал (тариалангийн аж ахуйдын тоо)

4. Хүнсний ногооны тариалангийн үүр амьсгалын ба зах зээлийн эрсдэл

Монголын газар тариалангийн үйлдвэрлэл олон төрлийн байгалийн эрсдэлтэй тулгарч байдаг. Байгалийн гамшигт үзэгдэлд өртөх нь бүс нутгийн байршил, таримлын төрлөөс шалтгаалан ялгаатай байх тул тухайн аж ахуйн байгалийн болон бусад эрсдэлд хэрхэн өртдөг талаар нарийвчлан судлах нь зүйтэй. Тариаланчдын байгалийн бэрхшээлд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлохдоо тэдэнд тулгардаг эрсдэлийн эх үүсвэр, учир шалтгааныг сайтар судлах шаардлагатай.


4.1. Тариаланчдад тулгарч байгаа эрсдэлүүд

Судалгаанд оролцсон хүнсний ногоочдод тулгардаг гол эрсдэлүүдийг Зураг 7-д үзүүлэв. Түүвэр судалгаанд багтсан тариаланчид өнгөрсөн жилүүдэд ямар нэгэн байдлаар үйлдвэрлэлийн болон зах зээлийн эрсдэлтэй тулгарснаа илэрхийлж байв. Тэдний хувьд хамгийн их дурдагдсан эрсдэлүүдэд үнийн хэлбэлзэл (64%), зуны хэт халалт, хуурайшилт (54%), хүчтэй аадар бороо, үер (49%) байсан юм. Эдгээр эрсдэлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд дараах чухал асуудлууд анзаарагдав. Нэгдүгээрт, зах зээл дэх үнийн тогтворгүй байдлаас шалтгаалан эрсдэл маш ихээр үүсэж байгаа нь сүл хөгжсөн, баталгаагүй нийлүүлэлтийн сүлжээнээс болж байна гэсэн дүгнэлтийг баталж байна. Тариаланчдын зах зээлийн үнээс хэт хамааралтай байдлыг багасгахын тулд албан ёсны гэрээ байгуулах явдлыг нэмэгдүүлэх талаар дорвитой арга хэмжээг авахгүй бол ахиц өөрчлөлт гарахгүй юм. Хоёрдугаарт, голлох таван эрсдэлийн гурав нь цаг агаартай холбоотой байна. Хэрэв уур амьсгалын өөрчлөлт сүүлийн үеийн таамаглалын дагуу үргэлжилбэл цаг агаарын эрсдэл нэмэгдэнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар Засгийн газар хоорондын зөвлөл (IPCC)-өөс гаргасан тайланд (2014) Азийн бүх бүс нутгийн температур нэмэгдэх боломж өндөр болохыг тооцоолсон бөгөөд зөвхөн Өмнөд ба Зүүн Азийн бүс нутагт болон далайн түвшнээс өндөрт орших орнуудад орох хур тунадсын хэмжээ нэмэгдэх талаар дурдсан байна. Жилийн дулааны нийлбэр температур нэмэгдэх нь нэг талаар Монгол улс шиг сэрүүн бүс нутгуудын газар тариаланд таатай нөлөөлж, талбайн хэмжээгээ нэмэгдүүлж үр ашигтай үйлдвэрлэл эрхлэхийг олон хүн зөвлөдөг боловч нөгөө талаар температурын өсөлт нь бэлчээрт болон мал аж ахуйн салбарт сөрөг нөлөө үзүүлэх юм. Үүнээс гадна цаг агаарын гамшигт үзэгдэл тохиолдох магадлал өсч байгаа нь хүнсний ногооны үйлдвэрлэгчдийг системийн хямралд оруулах магадлалтай (IPCC, 2014). Гуравдугаарт, дэлхий даяар маш олон ХАА-н системүүд нь ажиллах хүчний дутагдлын асуудалтай нүүр тулж байгаа бөгөөд энэ нь цаашид улам даамжрахаар байна. Монгол улсын хувьд 2019 онд ХАА-н салбарын ажилчдын тоо хамгийн бага хэмжээндээ хүрсэн бөгөөд энэ нь хот суурин газарт орлого олох илүү өргөн сонголтүүд байгаатай холбоотой юм. Ялангуяа залуу насны ангилалд хамрагдах ажилчдын тоо 2009-2019 оны хооронд хамгийн доод түвшинд хүрсэн байна. Тухайлбал, 15-19 насны ажилчид 70%-иар, 20-24 насны ажилчид 67%-иар, 25-29 насны ажилчид 43%-иар, 30-34 насны ажилчид 19%-иар тус тус буурсан нь газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд санаа зовох асуудал болж байна (ҮСХ, 2020). Газар тариалангийн ажилчдын тоо буурч буй асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй хэдий ч байнгын ажлын байрны гэрээ байгуулах нь эргэлзээтэй байдлыг бууруулахад хувь нэмэр оруулах боломжтой юм.



Зураг 7: Өнгөрсөн 10 жилд тариаланчдад тулгарсан эрсдэлүүд

Тулгарч байгаа зарим эрсдэлүүд нь газар тариалангийн үйлдвэрлэлд үзүүлэх бодит нөлөөний талаар бүрэн мэдээллийг хараахан өгч чадахгүй юм. Судалгаанд оролцсон хүнсний ногооны тариаланчдад тулгарч байгаа гол эрсдэлүүдийн үр дагаврыг Зураг 8-д үзүүлэв. Ихэнх эрсдэлийн төрлүүд нь 3-р (даван гарах боломжтой) ба 4-р (өндөр) зэргийн хооронд байсан бол зарим эрсдэл нь тариаланчдын хувьд илүү аюултай эрсдэлийн зэрэглэлд орсон байна. Ихэнх тариаланчдын хувьд хөрсний гүлсалт (82%), бороо орохгүй байх (76%), улирлын чанартай ширүүн бороо (72%) эсвэл хүнсний ногооны зэх зээлийн үнийн хөөрөгдөл (68.6%) зэрэг эрсдэлийг өндөр эсвэл маш сөрөг үр дагавар бүхий нөлөөтэй гэж үзсэн юм.




Зураг 8: Тулгарч байгаа эрсдэлүүдийн үр дагавар

Тариаланчдаас эрсдэл тулгарахад хэрхэн ханддаг талаар асуухад талаас илүү хувь нь (53%) эрсдэлээс зайлсхийх сонирхолтой байдгаа илэрхийлсэн бөгөөд энэ нь үйлдвэрлэлийн эрсдэл тохиолдоход тариаланчид эрсдэл багатай тариаланг сонгоно гэсэн үг юм. Харин судалгаанд оролцсон тариаланчдын зөвхөн 6.5% нь өөрсдийгөө эрсдэлээс зайлсхийж чаддаг гэж дүгнэсэн нь тэдний хувьд илүү эрсдэлтэй үйлдвэрлэлд хөрөнгө оруулах магадлалтайг харуулж байна. Энэ хувийн чанартай асуултаас гадна эрсдэл тохиолдсон үед тариаланчдаас гарах зан чанарыг илрүүлэхийг мөн зорьсон юм. Судалгааны нэг асуулт нь тэдэнд төлөх төлбөрийг барагдуулах хугацааг хойшлуулахтай холбоотой байсан бөгөөд судалгаанд хамрагдсан нийт тариаланчдын зөвхөн 29.6% нь үр ашгаа гуравны нэгээр нэмэгдүүлэхийн тулд төлбөр авахаа нэг сараар хойшлуулж болох юм гэж үзсэн. Судалгаанд оролцсон тариаланчдын хувьд хүлээлгийн хугацааны дараа төлбөр орж ирэх эсэх нь эргэлзээтэй байдаг тул төлбөрөө хойшлуулах нь илүү их эрсдэлтэй сонголт юм. Хоёр дахь асуултаар судалгаанд оролцогчдод хөрөнгө оруулалтын талаар дараах 2 сонголтын нэгийг сонгох боломж олгов. Үүнд, хөрөнгө оруулахад эрсдэлгүй сонголт буюу үр ашиг багатай боловч зээлийн төлбөр төлөхгүй байх сонголт, эсвэл үүнээс хоёр дахин илүү үр ашигтай боловч зээл төлөх чадвараа алдах магадлал нь 50% бүхий эрсдэлтэй хөрөнгө оруулалтын сонголт байв. Нийт тариаланчдын талаас илүү нь эрсдэл нь ил тод, боломжит ашиг нь хангалттай их гэсэн нөхцөл бүхий илүү эрсдэлтэй хөрөнгө оруулалтыг сонгосон байв. Иймээс нэмэлт мэдээлэл бүрдүүлж эрсдэлийг илүү ил тод болгох эсвэл эрсдэлийг тооцоолох боломжтой болгох замаар эрсдэлээс зайлсхийдэг тариаланчдад үйлдвэрлэлдээ хөрөнгө оруулалт хийх урам зориг өгөх боломжтой гэдэг талаар дурдах нь зүйтэй юм.

4.2. Үйлдвэрлэлийн ба зах зээлийн эрсдэлийг даван туулах

Тариаланчдын хувьд тулгарсан санхүүгийн хүндрэл, эрсдэлийн хор үршгийг даван туулахын тулд хамгийн түгээмэл хэрэглэдэг бөгөөд чухалд тооцогддог сонголт нь хамаатан садан, найз нөхдөөсөө болон банкнаас зээл авдаг болох нь судалгаагаар тогтоогдов. Харин малаа зарах, эсвэл газар тариалангийн болон хувийн үндсэн эд хөрөнгөө зарах нь хамгийн бага тохиолддог сонголт байв (Зураг 9). Тариаланчид нь зөвхөн онцгой тохиолдолд хэрэглээгээ багасгадаг бөгөөд ялангуяа тэдний гэр бүл нь үр хүүхдийнхээ боловсролд зарцуулах зардлыг танахаас зайлсхийдэг байна.

Судалгаанд оролцсон тариаланчдын 41.9% нь ярилцлага авах үед зээлийн үлдэгдэлтэй байгаагаа дурдсан бөгөөд арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагаас зээл авах нь эрсдэл бууруулах түгээмэл хэрэглэгддэг арга хэрэгсэл гэж тариаланчид үзэж байна. Зээлийн дундаж хүү нь 22%-тай тэнцэж байгаа нь зээлжих зах зээл хөгжөөгүй орнуудын хувьд түгээмэл түвшин бөгөөд энэ нь тариалангийн аж ахуйдад учрах санхүүгийн дарамт ба зээлээ төлөх чадвараа алдах байдал өндөр байгаагийн илэрхийлэл юм.




Зураг 9: Эрсдэлийг даван туулах аргууд

4.3. Эрсдэл тэсвэрлэх чадварыг сайжруулах аргууд

4.3.1. Эрсдэлийн удирдлагын уламжлалт аргуудыг хэрэглэх нь


Тариаланчдын ирээдүйд тохиолдож болох эрсдэлийг даван туулах чадавхыг сайжруулахын тулд авч хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын уламжлалт аргуудыг Зураг 10-т үзүүлэв. Судалгаанд хамрагдсан ихэнх тариаланчид хураасан ургацынхаа зарим хэсгийг нь хадгалах, эсвэл бага ургацтай хэдий ч эрсдэл багатай таримал тариалах, усалгааны тоног төхөөрөмж худалдан авах, тарих таримлын нэр төрлийг олшруулах зэрэгт хөрөнгө оруулалт хийх, тариалан эрхлэхээс өөр ажил хайж олох, банкны хадгаламжаа нэмэгдүүлэх зэрэг эрсдэлийн удирдлагын уламжлалт аргуудыг сонгосон байв. Эрсдэлийн удирдлагын бусад аргууд нь хангалттай хэмжээний хамгаалалт үзүүлдэггүй, эсвэл зардал ихтэй, хэрэглэхэд тохиромжгүй байгаа тул монголын хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн хувьд ач холбогдол багатай байгаа юм. Бидний судалгаанд түүвэрлэн оролцуулсан тариаланчид газар тариалангийн даатгалыг эрсдэлийн удирдлагын арга болгон бараг ашиглахгүй байгаа нь хачирхалтай хэрэг юм. Түүвэрт багтсан тариаланчдын зөвхөн гурав нь л ийм төрлийн эрсдэлийн удирдлагын стратегийг “заримдаа” ашигладаг бөгөөд эдгээрийн хоёр нь ургацын даатгалтай бол нэг нь малын даатгал эзэмшдэг байна. Харин нийт тариаланчдын 22% нь ХАА-н индексжүүлсэн даатгалын талаар огт мэдэхгүй байв. Тариаланчдын таримал ургамлын даатгалд хамрагдалт бага байгаагийн нэг шалтгаан нь одоогоор тариалангийн даатгалын бүтээгдэхүүн цөөн байгаатай холбоотой. Гэхдээ судалгаанд оролцсон тариаланчдын 97.7% нь банкинд барьцаа болгон ашиглаж болох иймэрхүү төрлийн эрсдэлийн удирдлагын бүтээгдэхүүнийг маш их сонирхож байгаагаа илэрхийлсэн байна. Мөн, Зураг 10-т нарийн судалгаа хийсний үр дүнд цөөн хэдэн тариаланчид зарим нэгэн эрсдэлийн удирдлагын аргыг эрчимтэй (“маш их”) ашиглаж байгааг харуулав. Гэхдээ энэ байдал нь тариаланчид эдгээр аргыг ашиглаад эрсдэлийн сөрөг үр дагавраас зайлсхийж чадна гэдэгтээ бүрэн найдахгүй байгаа эсвэл одоогоор хэрэглэж болох эрсдэлийн удирдлагын аргууд тохиромжгүй байгаатай холбоотой байж болох юм.




Зураг 10: Эрсдэлийн удирдлагын уламжлалт аргууд

4.3.2. Нэвтрүүлэх үйлчилгээний гүйцэтгэх үүрэг

Нэвтрүүлэх үйлчилгээг тариаланчдад тохиромжтой эрсдэлийн удирдлагын стратегийн талаар зөвлөгөө өгөхөд, үйлдвэрлэлийн эрсдэлийг бууруулах эсвэл түүний сөрөг үр нөлөөг багасгах орчин үеийн үйлдвэрлэлийн аргачлалыг хэрэгжүүлэхэд хэрэглэдэг. Судалгаанд оролцсон маш олон тариаланчид нэвтрүүлэх үйлчилгээний чанарыг дундаас сайны хооронд үнэлсэн (Зураг 11А) боловч тэдэнтэй нэвтрүүлэх үйлчилгээний ажилтан тогтмол ирж үүлздаггүй байна (Зураг 11Б). Эдгээр нэвтрүүлэх үйлчилгээг үзүүлдэг Газар тариалангийн албууд нь хэд хэдэн өөр ажлыг давхар хариуцдаг тул зав чөлөөнийхөө зөвхөн тодорхой хэсгийг л нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлэхэд зарцуулдаг болохыг орон нутгийн мэргэжилтнүүдээс мэдэж авсан юм. Бидний судалгаагаар нэвтрүүлэх үйлчилгээгээр гол төлөв таримлын сортын тодорхойлох, хөрсний ус хадгалах чадвар эсвэл цаг агаарын мэдээллийг өгдөг бол зарим тохиолдолд ээлжлэн тариалалт, усалгаа, эсвэл таримлын үлдэгдлийн менежментийн талаар мэдээлэл өгдөг байна (Зураг 12).




Зураг 11: Нэвтрүүлэх үйлчилгээ



Зураг 12: Нэвтрүүлэх үйлчилгээний мэдээллийн төрөл (хэд хэдэн асуултыг сонгож болно)

4.3.3. Дижитал технологийн гүйцэтгэх үүрэг

Дижитал технологи нь мэдээлэл ба эрсдэлийн удирдлагын хэрэгсэл болж өгөх боломжтой. Бидний судалгаагаар хүнсний ногооны тариаланчдын ихэнх нь ухаалаг гар утас (91%), зарим нь компьютер (20.8%), цөөн хэд нь таблет (7.8%) ашиглаж шаардлагатай мэдээллээ онлайнаар олж авдаг болохыг тогтоов (Зураг 13). Одоогоор монгол хэлээр газар тариаланд тусгайлан зориулсан гар утасны аппликэйшн байхгүй байгаа боловч тариаланчид цаг агаарын мэдээлэл шалгах (81%), зах зээлийн үнэ шалгах (61.2%), хураасан ургацаа зарах (44.1%) эсвэл үйлдвэрлэлдээ орц худалдан авах (42.4%) зэрэг эрсдэлийн удирдлагад хэрэгтэй мэдээлэл олж авахдаа эдгээр тоног төхөөрөмжийг ашигладаг байна.



Зураг 13: Дижитал хэрэглээ (хэд хэдэн асуултыг сонгож болно)

4.3.4. Нийлүүлэлтийн сүлжээний гүйцэтгэх үүрэг

Бүх аймгуудын хувьд борлуулалтын үйл ажиллагаа нь өндөр түвшинд байв. Таримал болон бүс нутгаас шалтгаалан нийт бүтээгдэхүүний 50 - 92.9 хувь нь борлуулагддаг (хувийн хэрэглээг эс тооцвол) байна. Хүснэгт 4-т тариалангийн аж ахуйн төрлүүдийн зах зээлд нэвтэрдэг олон төрлийн аргуудыг үзүүлэв. Судалгаанд оролцсон тариаланчдын ихээхэн хувь нь (дунджаар 50.3%) бүтээгдэхүүнээ орон нутгийнхаа зах зээлд шууд борлуулдаг. Энэ нь хүнсний ногоог богино хугацаанд борлуулах шаардлага болон ердийн захуудад хөргөх төхөөрөмж байхгүй зэрэгтэй холбоотой хамгийн эрсдэлтэй арга юм (Хүснэгт 4). Нийт хэрэглэгчдийн 11% нь өөрсдөө ирж худалдан авалт хийдэг явдал нь тариаланчдыг тээвэрлэлтийн зардлаас ангижруулах боловч энэ нь борлуулалтын явцад тулгардаг цаг хугацааны дарамтыг хөнгөвчлөхгүй юм. Тиймээс агуулах зоорины байгууламжид хөрөнгө оруулах шаардлагатай бөгөөд ингэснээр хэрэглэгчдийн бүтээгдэхүүнийг ирж авах үед гардаг гологдолтой холбоотой эрсдэлийг багасгана. Зах зээлийн үнийн хэлбэлзлээс хамгаалах чухал аргад тооцогддог гэрээт тариалан эрхлэх явдал тун ховор байна. Судалгаанд хамрагдсан нийт тариаланчдын зөвхөн 8% нь энэ нөхцөлийг ашиглан үйлдвэрлэлээ эрхэлдэг гэжээ. Тариалангийн зах зээлийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний төрлийг сонгох асуулгад судалгаанд оролцогчдын (нийт оролцогчдын 27.5%) нэлээд нь гэрээт тариалан эрхлэх төрлийг сонгосон. Харин 23.7% нь борлуулалтын хоршоонд нэгдэн ажиллах төрлийг сонгосон юм. Энэ нь худалдан авагчтай холбоотой гарах бэрхшээлийг борлуулалтын чиглэлээр төрөлжсөн нэгжид шилжүүлэх боломжийг олгох юм. Борлуулалтын хоршоонд хамрагдах төрлийг бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлдэг хоршоодын гишүүдийн ихэнх нь хэрэгжүүлдэг гэсэн бол харин өрхийн тариаланчдын 10.2%, аж ахуйн нэгжийн 11.8% нь хэрэгжүүлдэг гэсэн байна. Өрхийн тариаланчдын хувьд (62.3% нь) эрсдэлийн тодорхой нэг хэсгийг хянахад давамгайл хэрэглэдэг арга нь бүтээгдэхүүнээ дундын зуучлагчид (ченжээр) зарах явдал гэж үзсэн юм. Ингэснээр хэрэглэгч нэг бүртэй цаг зарцуулж хэлэлцээр хийхэд гарах эрсдэлийг өөр оролцогчид буюу ченжид шилжүүлэх боломж бүрдэнэ. Өрхийн тариаланчдын хувьд эрсдэлийг хуваалцах дээрх байдлаас өөр аргуудыг бараг ашигладаггүй байна. Албан ёсны гэрээт хэлэлцээр (бичгэн гэрээ) хийх нь бүх төрлийн тариалан эрхлэгчдийн дунд сайн хөгжөөгүй байгаа нь түүвэр судалгаанд оролцсон тариаланчдын зөвхөн 15.3% нь л энэ аргыг ашигладаг гэсэн байдлаас харагдаж байна. Албан ёсны гэрээ хийдэг гэж тариалангийн аж ахуйдын 33.3% нь илэрхийлсэн (хамгийн их

хувь) бол өрхийн тариаланчдын 7.3% нь (хамгийн бага хувь) ийм гэрээ хийдэг гэжээ. Албан ёсны гэрээ хийх түвшин бага байгаа нь тариаланчдыг, ялангуяа худалдаа хийх чадвар муутай, албан бус хэлэлцээрээр борлуулалтаа хийдэг жижиг өрхийн аж ахуйдыг зах зээлийн эрсдэл болон богино хугацааны үнийн хэлбэлзэл эсвэл бизнес хамтрагчдын төлбөр хойшлогдоход өртөмтгий болгож байна.

Зөвхөн цөөн тооны тариаланчид (судалгаанд хамрагдагчдын 7.1%) температурын тохируулга бүхий агуулах, зоорины байгууламжтай гэжээ. Тэгэхээр ихэнх тариаланчдын хувьд бүтээгдэхүүнээ борлуулах явцад гарч болох цаг хугацааны алдах эрсдэл болон хямд үнээр борлуулахаас хамгаалах арга байхгүй гэсэн үг юм. Судалгаанд оролцогчдын 68.5% нь энгийн агуулах, зоорьтой бөгөөд тэдгээр зоорийн багтаамж, хүчин чадал нь тийм ч их биш гэсэн намар бүтээгдэхүүний үнэ хэт хямд байгаа үед ургацынхаа тодорхой хэсгийг хадгалан, үнэ өсөх цагийг хүлээх боломжийг олгодог байна. Гэхдээ энэ хадгалсан бүтээгдэхүүний хэмжээ нь бага бөгөөд бүх бүтээгдэхүүнийг багтаахад хүрэлцэхгүй юм.

Хүснэгт 4: Нийлүүлэлтийн сүлжээний шинж чанар

	Борлуулалтын гэрээний төрөл Зах зээлд нэвтрэх боломж							Агуулах, Зоорь		
	Гишүүнчлэл бүхий борлуулалтын хоршоо	Зах зээлд шууд борлуулалт	Гэрээт тариалан эрхлэлт	Зуучлагчаар (ченжээр) дамжуулах	Хэрэглэгчид өөрсдөө ирж авах	Өөр хоршоогоор дамжуулах	Бичгэн гэрээ	Энгийн	Температурын хяналттай	Байхгүй
Өрхийн тариаланчид	10.2%	55.8%	3.4%	62.1%	8.7%	4.4%	7.3%	69.9%	3.4%	27.2%
Аж ахуйн нэгжүүд	11.8%	43.1%	27.5%	64.7%	11.8%	2.0%	33.3%	54.9%	25.5%	19.6%
Үйлдвэрлэл эрхлэгч хоршоод	90.2%	35.3%	5.9%	60.8%	17.6%	25.5%	29.4%	76.5%	3.9%	19.6%
Нийт	23.7%	50.3%	7.8%	62.3%	10.7%	7.5%	15.3%	68.5%	7.1%	24.7%

5. Шүүн хэлэлцүүлэг ба зөвлөмж

Энэхүү түүвэр судалгааны зорилго нь монголын хүнсний ногооны тариаланчдын үйлдвэрлэлийн эрсдэлд өртөмтгий байдал, одоогийн хэрэглэж байгаа болон цаашид хэрэгжүүлж болох эрсдэлийн удирдлага, эрсдэлийг даван туулах арга механизмын талаар хэлэлцэхэд оршино. Энэ судалгаа нь тариаланчдын мэдээлэл дээр тулгуурлаж эрсдэлийн гурван байдлыг тодорхойлов. Үүнд: байгаль орчны эрсдэл, зах зээлийн эрсдэл, хувийн эрсдэл орно. Тариаланчдын хувьд хамгийн их дурдсан эрсдэлүүд нь үнийн савлагаа буюу хэлбэлзэл, ажиллах хүчний хомсдол, ургамал ургалтын үеийн хэт халалт, хуурайшилт болон аадар бороо, үер байсан юм. Монгол улсын хүнсний ногооны салбарын үйлдвэрлэлийн өнөөгийн байдалд хийсэн уг судалгаа болон уур амьсгалын өөрчлөлтийн талаар олон улсын таамаглалаас дүгнэж үзэхэд эдгээр эрсдэл болон сөрөг үр дагавар нь цаашид улам нэмэгдэх магадлалтай байна.

Монголын ногоочид зах зээлийн харилцаанд нэгдэж оролцдоггүй, чанар болон нийлүүлэлтийн тоо хэмжээ баталгаагүй байдаг нь тус салбарыг үйлдвэрлэлийн болон зах зээлийн эрсдэлд өртөмтгий болгож байна. Энэ байдлаас шалтгаалан бүтээгдэхүүний өртгийн зардал өсөж, тариаланчдын үнийн хэлбэлзэл болон инфляцийг тэсвэрлэх чадвар буурч байна. Маш олон тооны тариаланчид гэрээт тариалан эрхлэхгүй байгаа боловч бүтээгдэхүүнээ дурын зах зээлд шууд нийлүүлж байна. Үүнээс гадна, Монгол улсын бараг бүх аймгуудад тулгарч байгаа нэг томоохон бэрхшээл нь үйлдвэрлэлийн орц (сорт, үр шинэчлэл, бордоо, УХБ)-ыг нэмэгдүүлж чадахгүй байгаа бөгөөд энэ нь бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхийг хязгаарлахаас гадна эрсдэлтэй нөхцөлд илүү тэсвэртэй шинэ сорт гаргахад хөрөнгө оруулалт хийх боломжийг бууруулдаг байна. Монгол улсад хүнсний ногооны салбарыг хөгжүүлэхийн тулд агуулах зоорины багтаамжийг нэмэгдүүлэх, түүнчлэн хүнсний зах, дэлгүүрүүдэд шаардлагатай хөргөлттэй агуулах, зоорийн дутагдалтай байдлыг арилгах зайлшгүй шаардлагатай байна. Газар тариалангийн үйлдвэрлэлийн орцууд болох үр, бордоо, ургамал хамгааллын бодис борлуулдаг дэлгүүрүүд нь тариаланчдаас хол байдаг тул тэнд гарах тээвэрлэлтийн зардал нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртөг, зардлыг өсгөж байна.

Монгол улсын газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжийн ихэнх нь хувийн эсвэл арилжааны зээлийг ашиглах замаар эрсдэлийг бууруулах сонголтоо хийж байна. Энэ судалгааны үеэр банкны зээлийн талаар авсан мэдээллийн дагуу үндэсний валютын зээлийн хүү буурахад газар тариалангийн зээлжих боломж нэмэгдэх болно. Зээлийн хүү бага байх нь тариаланчдад тариалангийн аж ахуйн технологид хөрөнгө оруулах боломжийг олгох бөгөөд ингэснээр тэдний цаг агаарын эрсдэлд өртөмтгий байдлыг бууруулна. Харин зээлийн хүү өндөр байх эсвэл зээлийн бусад тааламжгүй нөхцлүүд нь эрсдэлийг даван туулах стратегийг өөрчилж тариаланчдын өртөмтгий байдлыг сайжруулах биш улам муутгана. Иймэрхүү төрлийн зээл нь нөхөн төлөх, барьцаагаа алдах гэх мэтээр санхүүгийн хүнд дарамтыг тариаланчдад үүсгэдэг. Монголын хүнсний ногооны тариаланчдад эрсдэлийн удирдлага буюу ирээдүйн эрсдэлд өртөмтгий байдлыг бууруулахад тохиромжтой, сонголт хийх арга механизм байхгүй байна. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг эрсдэлийн удирдлагын аргуудад агуулахтай болох, эрсдэл багатай таримал тариалах, эсвэл усалгаа хийх гэх мэт уламжлалт арга хэмжээнүүд орж байна. Хүнсний ногооны тариаланчдын эрсдэлийн удирдлагын аргачлалд газар тариалангийн даатгал эсвэл урьдчилгаат гэрээт борлуулалт гэх мэт илүү орчин үеийн эрсдэлийн удирдлагын арга хэрэгсэл дутагдаж байна.

Дэлхийн бусад бүс нутгуудын адилаар эрсдэл нэмэгдэхэд газар тариалангийн үйлдвэрлэгчдийн эрсдэлийн удирдлагын арга хэрэгслүүдийг боловсронгуй болгох, хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Одоо хэрэглэгдэж байгаа эрсдэлийн удирдлагын багахан хүрээг хамарсан аргуудыг бодвол илүү тогтвортой шийдлүүд бүхий хэд хэдэн эрсдэлийн удирдлагын аргууд байдаг. Одоогийн байдлаар эдгээр эрсдэлийн удирдлагын аргуудыг сонгож нэвтрүүлэхгүй байгаа нь дээрх технологиуд нь аж ахуйн орлогыг нэмэгдүүлнэ гэдэгт найдахгүй, дэд бүтэц хангалтгүй, ногоочид зах зээлд нэгдэж оролцдоггүй, өртгийн сүлжээний хөгжил сул байгаа зэрэгтэй холбон тайлбарлаж болно. Эдгээр эрсдэлүүд болон өртгийн сүлжээний бэрхшээлүүд нь газар тариалангийн хөрөнгө оруулалтад саад учруулж байгаа тул ургацын хэмжээ нь хөрш орнуудынхтай харьцуулахад доогуур байгаа юм. Тиймээс тариаланчдын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх, тэдний үйлдвэрлэлд шинэ технологи, хөрөнгө оруулалт татах ажлыг бодлогоор дэмжиж, хөрш орнуудын адилаар бүтээмжийг нь нэмэгдүүлэхийн тулд шат дараатай арга хэмжээ авах шаардлагатай байна.

Нэгдүгээрт, нийлүүлэлтийн сүлжээний болон зах зээлд нэвтрэх үр ашиггүй байдлыг арилгах нэг боломжит шийдэл бол дижиталчлалыг нэвтрүүлэх юм. Монгол улсын алслагдсан бүс нутгийн

тариаланчдыг оролцуулаад нийт тариаланчдын ихэнх нь бүтээгдэхүүний зах зээлийн үнэ зэрэг шаардлагатай мэдээлэл олж авах боломжоо сайжруулах, үйлдвэрлэлийн өртгийн зардлаа бууруулахын тулд технологио сайжруулсан байна. Ялангуяа өдөр ирэх бүр хямд болж буй гар утасны аппликэйшнийг энэ зорилгоор ашиглаж болох юм. Гар утасны аппликэйшнийг хөгжүүлбэл тариаланчид нь утсан дээрээ үнэгүй суулган авснаар мэдээллийг шууд зардалгүй олж авахаас гадна, борлуулалтын зардал ч бараг гарахгүй байх боломж бүрдэнэ. Энэ чухал сайжруулалтыг хэрэгжүүлэхийн тулд зөөврийн интернетийн хамрах хүрээг сайжруулах, монгол хэлээр програм боловсруулах зэргээс эхлэх хэрэгтэй.

Хоёрдугаарт, дижиталчлалыг нэвтрүүлэх үйлчилгээний сүлжээний тасралтгүй байдлыг сайжруулахад ашиглаж болох юм. Хүнсний ногоо тариалдаг нутгуудын ихэнх нь хот суурин газруудтай харьцангуй ойрхон байршсан байдаг боловч Монгол улсын газарзүйн нөхцөл байдал нь нэвтрүүлэх үйлчилгээний зардлыг нэмэгдүүлж, цаг илүү их зарцуулах шаардлагатай болгож байдаг. Ийм нөхцөлд улсын нэвтрүүлэх үйлчилгээнд бүрэн найдах боломжгүй юм. Эдийн засгийн шилжилт хийж байгаа Азийн орнуудад, ялангуяа Хятад улсад, уламжлалт болон орчин үеийн нэвтрүүлэх үйлчилгээг хослуулах замаар энгийн, сүүлийн үеийн мэдээлэл бүхий гар утасны аппликэйшн нэвтрүүлж хамгийн хурдан, хямд аргаар шийдэлд хүрч байна. Мөн үйлдвэрлэл эрхлэх шинэ арга, инновацийг нэвтрүүлэхэд уламжлалт аргуудыг, тухайлбал талбайн үзүүлэх сургалт хийх зэрэг нь хүнд илүү сайн хүрэх боломжтой. Харин өөр нэг боломжит арга нь хувийн нэвтрүүлэх үйлчилгээг дэмжих бөгөөд энэ талаар шилжилтийн эдийн засаг бүхий Узбекистан улсын жишээг дурдаж болно. Узбекистан улсад өнгөрсөн жилүүдэд улсын нэвтрүүлэх үйлчилгээний зэрэгцээ хувийн нэвтрүүлэх үйлчилгээг туршилт маягаар хэрэгжүүлсэн бөгөөд үүний үр дүнд мэдээллийн болон газар тариалангийн орцын хангамж сайжирсан байна.

Гуравдугаарт, энэ судалгааны үр дүнгээс дүгнэж үзэхэд, даатгалын үйлчилгээний зах зээлийг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай нь тодорхой байна. Монголын мал аж ахуйн салбарт хийсэн өмнөх судалгаануудын үр дүнд санхүүгийн эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийн хэрэгцээ их байгаа нь тодорхой болсны нэгэн адилаар хүнсний ногоо тариаланчид нь зээл авах эсвэл санхүүгийн бусад дэмжлэгтэй холбоотой асуудлыг ихээр сонирхож байгаа нь ажиглагдлаа. Монгол улсын улаан буудайн салбарт хиймэл дагуулд тулгуурласан ургамал ургалтын мэдээллийг ашиглан индексжүүлсэн газар тариалангийн даатгалын ажлыг туршилтын байдлаар 2020 онд эхлүүлжээ. Энэхүү судалгааны үзүүлэх нөлөө, мэдээлэл дамжуулах туршилтыг ойрын хугацаанд хийхээр төлөвлөж байна.



Дөрөвдүгээрт, Дээр дурдсан сайжруулалтын боломжуудыг тодорхойлохын тулд цаашид шинжлэх ухаанд тулгуурласан нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай. Ялангуяа, монголын хүнсний ногооны тариаланч бүрийн хэрэгцээг хангахын тулд хэрэгцээнд тулгуурласан эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийг судалж хөгжүүлэх шаардлагатай байна. Бусад улс орнуудын газар тариалангийн хөгжлийн туршлагаас харахад газар тариалангийн бодлогын хэрэгжилт, түүний үр дүн нь тариаланчдын шаардлагад хэрхэн нийцэж байгаатай шууд хамааралтай байна. Олон улсын хэмжээнд эрсдэлийн удирдлагын төрлүүд, эрсдэлийн сөрөг үр дагаврыг даван туулах, арилгах аргын үр ашгийн талаар олон тооны судалгаа, шинжлэх ухааны бүтээл байгаа боловч Монгол улсын газар тариалангийн аж ахуйн нэгжүүд эдгээр аргууд нь тохирох эсэх, хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар үр нөлөөний шинжилгээ хийх шаардлагатай юм. Зөвхөн энэ үйл ажиллагааг хэрэгжүүлснээр тухайн сонгосон аргын үр ашгийг тариаланчид мэдэрч, тэдний итгэл найдвар нь сэргэнэ. Монголын хүнсний ногооны үйлдвэрлэгчдэд одоогийн үйлдвэрлэлийн болон зах зээлийн эрсдэлийн талаар ойлголт



өгөхийг зорьж энэ тайланд тусгасан эрсдэлүүдэд мэдрэмжийн судалгаа хийсэн бөгөөд энэ нь цаашид тэднийг хөгжлийн зөв чиглэлд оруулах эхлэл болно гэж найдаж байна. Аж ахуйн нэгжүүдийн түвшний мэдээнд хийх эконометрийн дүн шинжилгээ, талбайн туршилтууд буюу санамсаргүй хяналттай туршилтууд нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсний үр дүн болон хүчин зүйлүүдийг тодорхойлох дараагийн шатны ажлууд юм.



Ашигласан хэвлэл:

- АХБ (2020). “Монгол Улсын Хүнсний Ногооны Үйлдвэрлэлийн Өртгийн Сүлжээ”. Азийн Хөгжлийн Банк, Манилла Хот, Филиппин улс.
- АГАБТ (2020). Гишүүн Орнуудад Гамшгийн Эрсдэлийг Бууруулах Талаарх Мэдээлэл. Азийн Гамшгийн Аюулыг Бууруулах Төв (АГАБТ).
- НҮХХААБ, НҮБ-ын Хүүхдийн Байгууллага, НҮБ-ын Хөгжлийн Байгууллага (2007). “Монгол Улсын Хүнсний Аюулгүй Байдалд Хийсэн Хамтын Дүн Шинжилгээ”. НҮХХААБ, НҮБ-ын Хүүхдийн Байгууллага, НҮБ-ын Хөгжлийн Байгууллага, Улаанбаатар хот, Монгол улс.
- НҮХХААБСТАТ (2020). Хүнс, Хөдөө Аж Ахуйн Статистик Мэдээлэл. Нэгдсэн Үндсэн Байгууллагын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага, Ром хот.
- IPCC (2014). “Уур Амьсгалын Өөрчлөлт 2014 – Үр Нөлөө, Дасан Зохицох ба Өртөмтгийн Байдал: Боть 2, Хөдөө Орон Нутгийн Байдал: IPCC-ийн Тавдах Шинжилгээний Тайланд Working Group II-ын Оруулсан Хувь Нэмэр” Камбридж Их Сургуулийн Хэвлэл, Нью Ёрк хот.
- МСМС (2020). БАЙГАЛИЙН ГАМШИГ БА ТҮҮНИЙ ХОР УРШИГ-ийг гол үзүүлэлт, улсын түвшинд сар сараар нь үзүүлсэн мэдээлэл. Монголын Статистик Мэдээллийн Систем, Улаанбаатар.
- Пешк, Б. (2016). “Монголын Жимс ба Хүнсний Ногооны Бүтээгдэхүүний Өртгийн Сүлжээний Хөгжил”. ИАК АГРАР КОНСУЛТИНГ ХХК, Лайпциг хот.

Хавсралт: Түүврийн байршил







Эх сурвалж: Өөрсдийн хийсэн танилцуулга

Тайлбар: Зарим тохиолдолд тариаланчдыг судалгаанд оролцуулахын тулд захиргааны байранд урьж үүлсэн болно. Тиймээс ярилцлага өгсөн газар нь түүвэр судалгаанд багтсан тариалангийн аж ахуйн нэгжийн байршлаас өөр байхыг үгүйсгэхгүй болно.